



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 3/05

Жаргалтхаан сум

Т.Төгөлдөрийг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6, 43 дугаар зүйлийн 43.3.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 1 дүгээр хавсралт, “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Зоригтын Жанчив нь жирэмсний амралтаа авсан тул Төртогтохын Төгөлдөрийг Засаг даргын Тамгын газрын даргын Төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Эрдэнэхүү – Санхүүгийн албаны дарга

Гишүүд: Ц.Гантөмөр – Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Д.Мөнхбаяр – Нярав

3. Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Т.Төгөлдөрт үүрэг болгосугай.

2.

4.Т.Төгөлдөрийн үндсэн цалинг ТЗ-8 шатлал буюу 1399000 (нэг сая гурван зуун ерэн есөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 2 хувь, орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 60 хувиар тус тус тооцож цалинжуулахыг нягтлан бодогч Т.Энхсайханд зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.МӨНХДЭЛГЭР